



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 08 өдөр

Дугаар A/408

Эрдэнэт

Цэргийн дүйцүүлэх алба хаагчдаар
үүрэг гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/б/, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, 2008 оны "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын тухай 49 дүгээр тогтоолын 10 дугаар зүйлийн А, Б заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1"Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 20 алба хаагчдаар Баян-Өндөр сумын Эрдэнэ баг, Булган аймгийн Орхон сумын Халиун багийн нутаг дэвсгэрт 2017 оны 06 дугаар сарын 28-ны орой орсон хүчтэй аадар бороо, салхины улмаас үүссэн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд 2017 оны 06 дугаар сарын 28-30-ны хооронд 3 хоног, орон нутагт дахь батлан хамгаалах үйл ажиллагаанд 07 дугаар сарын 08-13-ны хооронд 5 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгүүлэхийг Цэргийн штабын дарга /хурандаа Батсуурь/-д даалгасугай.

2.Цэргийн дүйцүүлэх алба хаагчдаар үүрэг гүйцэтгүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын ажил үүрэг гүйцэтгэхэд шаардагдах 440000 /Дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийг орон нутгийн цэрэг татлага, дүйцүүлэх албаны цугларалт, бэлтгэл сургуулилтын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
0200001847

Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 405 дугаар захирамжийн хавсралт

**ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧДААР
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Ажлын багаж хэрэгслийн зардал					
1.	Ажлын бээлийн	хос	40	2000	80000
Бүгд					80000
2.Хоол,цай ундааны зардал					
1.	Хоол /2017 оны 06 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд/	20	2 өдөр	6000	240000
Бүгд					240000
Тээврийн зардал					
1.	Бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх /Зил-131/	80	А-80	1500	120000
Бүгд					120000
Нийт					440000